



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДУА-2025/05/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Дундговь аймаг

2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Оюун-Эрдэнэ

Утас: 70592225

Цахим хаяг: oyunerdenet@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан

Утас: 70593113

Цахим хаяг: batsaikhant@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
5. Аудитын илрүүлэлт	8
5.1.1 Албан шаардлага	8
5.1.2 Зөвлөмж	8
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ДЭЛГЭРХАНГАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ж.ӨЛЗИЙЖАРГАЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант онд Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 310,709.1 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн татварын орлого 152.1 хувиар биелэсэнтэй холбоотой байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал байхгүй.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 хөтөлбөр, 13 зорилт, 90 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 95.9 хувийн гүйцэтгэлтэй

4825020275

тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын Засаг даргын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр ирүүлсэн болно.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	771,715.4	1,127,961.2
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	398,247.7	708,956.8
33	АВЛАГА	168,271.8	144,859.5
35	БАРАА МАТЕРИАЛ	205,195.9	274,144.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,485,403.4	1,650,880.1
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,485,403.4	1,650,880.1
39200	Биет хөрөнгө	1,393,224.9	1,562,342.2
39300	Биет бус хөрөнгө	92,178.5	88,537.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,257,118.8	2,778,841.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,542.0	31,108.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,542.0	31,108.2
41300	Өглөг	1,542.0	30,573.2
41400	Урьдчилж орсон орлого	-	535.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,255,576.8	2,747,733.1
51	Засгийн газрын хувь оролцоо	2,255,576.8	2,747,733.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	476,916.6	476,916.6
51200	Хуримтлагдсан үр дүн	1,611,321.6	2,103,477.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	167,338.5	167,338.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,257,118.8	2,778,841.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,795,832.60	2,612,807.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	332,699.10	801,197.20
110	Орлогын албан татвар	211,221.40	658,418.90
1100	Хувь хүний орлогын албан татвар	211,221.40	658,418.90
113	Хөрөнгийн албан татвар	45,684.80	48,910.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	75,792.80	93,868.30
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	401,721.60	362,110.00
120	Нийтлэг татварын бус орлого	401,721.60	362,110.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,061,411.80	1,449,500.20
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,235,536.10	1,712,336.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,235,536.10	1,712,336.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,211,418.80	1,637,651.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	390,261.90	612,638.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,689.20	74,430.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,415.60	438,214.30
2104	Хангамж, бараа материалын зардал	41,480.10	46,870.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,848.60	17,720.90
2107	Томилолт, зочны зардал	19,594.00	25,514.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	385,143.40	47,135.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	286,986.10	375,127.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,117.30	74,684.90

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	560,296.40	900,470.90
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	143,744.90	401,433.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	416,551.50	499,037.80

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,839,024.6	1,839,024.6
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.7	0.7
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,839,025.3	1,839,025.3
9	Тайлант үеийн үр дүн	416,551.5	416,551.5
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,255,576.8	2,255,576.8
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,255,576.8	2,255,576.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(6,881.5)	(6,881.5)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,248,695.3	2,248,695.3
19	Тайлант үеийн үр дүн	499,037.8	499,037.8
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,747,733.1	2,747,733.1

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,589,864.60	2,388,899.30
11	ТАТВАРЫН ОРЛОГО	332,727.90	801,168.40
110	Орлогын албан татвар	211,250.20	658,390.20
1100	Хувь хүний орлогын албан татвар	211,250.20	658,390.20
113	Хөрөнгийн албан татвар	45,684.80	48,910.00
118	Бусад татвар, төлбөр, хураамж	75,792.80	93,868.30
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	5,541.00	9,076.40
1181	Газрын төлбөр	69,963.90	67,966.30
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	288.00	16,825.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	195,724.80	138,230.70
120	Нийтлэг татварын бус орлого	195,724.80	138,230.70
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,061,411.80	1,449,500.20
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,079,103.40	1,521,076.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,079,103.40	1,521,076.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,054,986.10	1,446,400.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	390,083.90	612,856.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,688.50	74,430.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	27,415.60	426,310.30
2104	Хангамж, бараа материалын зардал	36,329.90	35,702.30
2105	Нормативт зардал	650.00	1,045.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,781.30	19,106.50
2107	Томилолт, зочны зардал	19,594.00	25,514.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	385,194.50	47,135.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	131,248.50	204,300.10

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,117.30	74,676.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	510,761.20	867,822.50
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	459,229.70	557,113.40
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	459,229.70	557,113.40
2200	Дотоод эх үүсвэрээр	459,229.70	557,113.40
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(459,229.70)	(557,113.40)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(158,400.00)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(106,868.60)	310,709.10
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	505,116.20	398,247.70
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	398,247.70	708,956.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,612,279.1	2,029,051.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,682,336.5	1,484,627.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,611,935.1	1,414,245.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	613,059.4	612,856.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	75,020.8	74,430.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	422,216.8	419,076.5
2104	Хангамж, бараа материалын зардал	32,783.8	32,775.6
2105	Нормативт зардал	1,045.0	1,045.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	30,475.3	30,192.8
2107	Томилолт, зочны зардал	25,854.0	25,514.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	44,640.1	44,639.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	366,839.9	173,714.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	70,401.4	70,382.6
2132	Бусад урсгал шилжүүлэг	70,401.4	70,382.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	873,672.4	544,423.4
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	56,270.2	0.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,612,279.1	2,115,130.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	592,881.9	569,166.9
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,454,241.4	1,427,107.6
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	565,155.8	118,856.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		311,095.5
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		397,175.3

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	46,921.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	46,921.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	42,627.7
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,233.8
2104	Хангамж, бараа материалын зардал	2,926.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,603.7

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,495.7
2108	Бараа үйлчилгээний бусад зардал	28,367.7
2109	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,293.6
213	Олгосон санхүүжилт шилжүүлэг	4,293.6
I	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	46,921.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	46,921.2

5. Аудитын илрүүлэлт

5.1 Сумын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын Засаг даргын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитаар **45,534.9** мянган төгрөгийн зөрчил¹ илрүүлж, татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой **1** заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

Мөн аудитын явцад тусгай зориулалтын сангуудыг шалгахад **2,000.0** мянган төгрөгийн зөрчил илэрч, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлжээ.

Залруулагдаагүй алдаа:

Аудитаар нийт **47,534.9** мянган төгрөгийн зөрчил² илрүүлж, **2,000.0** мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага, татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой зөрчилд **45,534.9** мянган төгрөгийн **1** заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн.

5.1.1 Албан шаардлага

1. Аудитаар дахиврыг дахин ашиглах зорилгоор иргэнтэй гэрээ байгуулан **1,500.0** мянган төгрөгийг буцалтгүй дэмжлэг хэлбэрээр олгож, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т */батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих/*, "Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын 3.1-т */Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасан хувь, хэмжээний доод хязгаартай тэнцэх төлбөрийн орлогын хэсгийг тухайн ашигласан нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, хяналт тавих арга хэмжээнд зарцуулна/* заасныг тус тус зөрчсөн байна.

2. Аудитаар санхүүгийн тайлан дахь **500.0** мянган төгрөгийн барьцаа хөрөнгийн өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д */дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах/*, 20.2.6-д */эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах/* заасныг тус тус зөрчсөн байна.

5.1.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

1. Татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Илрүүлэлт: 2024 оны татварын орлогын төлөвлөгөөг нийт дүнгээр 152.1 хувиар буюу 279,451.7 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн боловч 3 нэр төрлийн орлогын төлөвлөгөөг **45,534.9** мянган төгрөгөөр тасалсан, татварын орлогын төлөвлөгөөний жигд биелэлтийг хангах ажлыг хангалтгүй хэрэгжүүлсэн.

Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.19. -д /нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах; /, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3.-т /санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;/, 41 дүгээр зүйлийн 41.2.-т /Бүх шатны төсөв захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ/, 41.2.1.-т /Хуулийн дагуу, улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухай төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/, Татварын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.30.-д /"татварын улсын байцаагч" гэж энэ хуулийн дагуу татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлж, татвар төлөгчид үйлчлэх, татвар хураах, тайлан хүлээн авах, хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий татварын албанд ажилладаг, эрх олгогдсон төрийн захиргааны албан хаагчийг/ заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж:

- Татварын болон татварын бус орлогыг тайлант оны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, өмнөх оны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, орлогын нэр төрлийг бүрэн төвлөрүүлэх.
- Сумын татварын алба буюу татварын байцаагч, татварын орлого бүрдүүлэлтэд хамаарах алба хаагч нарыг удирдлагаар хангаж, ажлын хариуцлагыг нь сайжруулж, хууль тогтоомжид заасан эрх, үүргээ хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2025 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо			Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр		Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан				

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн сан	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 5,625.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс аудитын явцад 535.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 5,090.0 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлээ. Үүнээс аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 90.5 хувийг залруулагдаагүй, 9.5 хувийг залруулсан алдаа тус тус эзэлж байна.

Төсөвт байгууллагуудын 2024 санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн завсрын аудитаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн 2,000.0 мянган төгрөгийн 2 албан шаардлагыг хэрэгжүүлэн нотлох баримтыг ирүүлсэн байна. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулагдах боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 2,000.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшнээс 13.7 дахин бага байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл:

№	Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Хоршоо хөгжүүлэх сан	1	535.0			1	535.0	1	535.0				
	Дүн	1	535.0			1	535.0	1	535.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

д/д	Байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс:											
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал			
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Засаг даргын Тамгын газар	1	400.0			1	400.0								
	Орон нутгийн хөгжлийн сан	1	-			1	-								
2	Тусгай зориулалтын сан	2	2000.0			2	2,000.0								
	Нийт зөрчлийн дүн	4	2,400.0	-	-	4	2,400.0	-	-	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
2. Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Засаг даргын Тамгын газар	1	3,980.0			1	3,980.0		
Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	1	710.0			1	710.0		
Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлан	1	45,534.90					1	45,534.9
Дүн	3	50224.9			0	0	2	4,690.0
Нийт дүн	3	50,224.9			-	-	2	4,690.0